



МОНГОЛ УЛС
БАЯНХОНГОР АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2023 оны 10 сарын 31 өдөр

Дугаар А/577

Номгон

Г 7
Батлан хамгаалах бодлого, хууль
тогтоомжийн хэрэгжилтэд хяналт,
шалгалт явуулах тухай

“Батлан хамгаалах тухай хууль”-ийн 18 дугаар зүйлийн 18.1.1, 18.1.3 дахь заалт, 17 дугаар зүйлийн 17.1.1 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Байгууллага, аж ахуйн нэгжүүдэд “Үндэсний аюулгүй байдлыг хангах тухай хууль”, “Батлан хамгаалах тухай хууль”, “Цэргийн албаны тухай хууль”, “Дайчилгааны тухай хууль”, “Орон нутгийн хамгаалалтын тухай хууль”, “Зөрчлийн тухай хууль” зэрэг хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт шалгалт явуулсугай.


2.Комиссын бүрэлдэхүүнийг нэгдүгээр, хяналт шалгалтад хамрагдах байгууллагуудын нэр, хуваарийг хоёрдугаар, шаардагдах зардлыг гуравдугаар хавсралтаар тус тус баталсугай.

3.Хяналт, шалгалтын ажлыг чанартай зохион байгуулж явуулахыг Засаг даргын Тамгын газрын Цэргийн штабын дарга (хурандаа Г.Нэмэхбаяр)-д үүрэг болгосугай.

4.Дээрх арга хэмжээнд шаардагдах 764,920 (Долоон зуун жаран дөрвөн мянга есөн зуун хорин) төгрөгийг Цэргийн дүйцүүлэх албаны мөнгөн төлбөрийн орлогын орон нутагт үлдэх хэсгээс зарцуулахыг Санхүү, төрийн сангийн хэлтэс (С.Байгалмаа)-т зөвшөөрсүгэй.

5.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын орлогч (Б.Батсуурь)-д даалгасугай

ДАРГА



Д.МӨНХСАЙХАН

642311517

Аймгийн Засаг даргын 2003 оны 10 дугаар
сарын 31-ний өдрийн 1577 дугаар захирамжийн
нэгдүгээр хавсралт

ШАЛГАЛТЫН КОМИССЫН
БҮРЭЛДЭХҮҮН

Комиссын дарга:

Г.Нэмэхбаяр

Засаг даргын Тамгын газрын Цэргийн штабын дарга,
хурандаа

Нарийн бичгийн дарга:

Г.Бат-Өлзий

Орон нутгийн хамгаалалтын бэлтгэл, сургалтын
офицер, хошууч

Гишүүдэд:

Т.Мөнхбат

Дайчилгааны офицер, дэд хурандаа

Г.Болдбаатар

Тоо бүртгэлийн ахлах офицер, хошууч

оОо

Аймгийн Засаг даргын 2023 оны 10 дугаар сарын 31-ний өдрийн 1577 дугаар захирамжийн хоёрдугаар хавсралт

БАЙГУУЛЛАГА, АЖ АХУЙН НЭГЖҮҮДЭД 2023 ОНД
БАТЛАН ХАМГААЛАХ ХУУЛЬ, ТОГТООМЖИЙН
ХЭРЭГЖИЛТИЙГ ШАЛГАХ ХУВААРЬ

№	Байгууллагуудын нэр	Хугацаа сар												Тайлбар	
		1	2	3	4	5	6	7	8	9	10	11	12		
1	Хас банк												+		
2	Голомт												+		
3	Хаан банк												+		
4	Төрийн банк												+		
5	Номундалай цогцолбор сургууль												+		
6	Биеийн тамир спортын газар												+		
7	Хүнс хөдөө аж ахуйн газар												+		
8	Мал эмнэлгийн газар												+		
9	"Баянхонгор-Эрчим хүч" ЦТХХК												+		
10	Байгаль орчин аялал жуулчлалын газар												+		
11	Татварын хэлтэс												+		
12	Стандарт хэмжилзүйн төв												+		

Аймгийн Засаг даргын 2023 оны 10 дугаар
сарын 31-ний өдрийн 1577 дугаар
захирамжийн гуравдугаар хавсралт

ЗАРДЛЫН ТООЦОО

Д/д	Зардалын нэр	Тоо	Нэг бүрийн үнэ	Нийт дүн
1	Гарын авлага, сурталчилгааны материал	1000 ширхэг	350 төг	350.000 төг
2	Шатахуун	164 л	2530 төг	414,920 төг
ДҮН			764,920 төг	

_____ оОо _____